

**ВИЗИЙН ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн тохиролцогч талууд" гэх/,

Хоёр улсын хоорондын найрсаг харилцааг хөгжүүлэхийг эрмэлзэн,

Хэлэлцэн тохирогч талуудын иргэдийн харилцан зорчих явдлыг хөнгөвчилж, хүчин төгөлдөр зорчих бичиг баримт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх зорилгоор

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

1 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын иргэн энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд дурдсан хүчин төгөлдөр зорчих бичиг баримтаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт орсон өдрөөс хойш хуанлийн нэг жилийн хугацаанд 90 (ер) хүртэл хоног визгүй орж, гарч, дамжин өнгөрч, мөн түр хугацаагаар оршин суух эрхтэй.

2 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрт дурдсан хүчин төгөлдөр зорчих бичиг баримт гэдэгт:

Бүгд Найрамдах Беларусь Улсын иргэдийн хувьд:

Бүгд Найрамдах Беларусь Улсын иргэний дипломат паспорт;

Бүгд Найрамдах Беларусь Улсын иргэний албан паспорт;

Бүгд Найрамдах Беларусь Улсын иргэний паспорт;

Бүгд Найрамдах Беларусь Улсад буцах гэрчилгээ (зөвхөн Бүгд Найрамдах Беларусь Улсруу буцах тохиолдолд)

Монгол Улсын иргэний хувьд:

Монгол Улсын иргэний дипломат паспорт;

Монгол Улсын иргэний албан паспорт;

Монгол Улсын иргэний гадаад паспорт;

Монгол Улсын түр паспорт (Буцах үнэмлэх).

3 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хүчин төгөлдөх зорчих бичиг баримт эзэмшигч иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт 90 (ер) хоногоос дээш хугацаагаар зорчих хүсэлтэй бол тухайн улсын хууль тогтоомжийн дагуу виз авна.

4 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэр дэх Дипломат төлөөлөгчийн газар, консулын газар болон олон улсын байгууллагад ажиллахаар томилогдсон Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд болон гэр бүлийн гишүүд нь томилогдсон бүхий л хугацааныхаа туршид хүлээн авагч Хэлэлцэн тохиролцогч талын нутаг дэвсгэрт визгүйгээр нэвтрэх, дамжин өнгөрөх, оршин суух болон гарна.

5 дугаар зүйл

Хүчин төгөлдөр зорчих бичиг баримт бүхий Хэлэлцэн тохиролцогч нэг талын иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт орж, гарах болон дамжин өнгөрөхдөө Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын гадаад иргэдийн орох, гарах, дамжин өнгөрөх тухай хууль тогтоомжийн дагуу олон улсын зорчигч тээвэрт зориулсан хилийн боомтоор нэвтэрнэ.

6 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын иргэд нөгөө талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа суугаа улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүргийг энэхүү Хэлэлцээр хөндөхгүй.

7 дугаар зүйл

Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан иргэнийг Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал хүлээн авах боломжгүй гэж үзэн нутаг дэвсгэртээ оруулахаас татгалзах, оршин суух хугацааг нь богиносгох, хязгаарлах талаарх эрх бүхий байгууллагын бүрэн эрхийг энэхүү Хэлэлцээрээр хөндөхгүй.

8 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал, өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журам, нийтийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр хугацаагаар зогсоож болно. Ийм арга хэмжээ авсан, эсхүл Хэлэлцээрийн үйлчлэлийг сэргээсэн тухайгаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа дипломат шугамаар нэн даруй мэдэгдэнэ.

9 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд дурдсан хүчин төгөлдөр зорчих бичиг баримтын загварыг Хэлэлцээрт гарын үсэг зурсанаас хойш 30 (гуч) хоногийн дотор харилцан дипломат шугамаар солилцоно.

Хэлэлцэн тохиролцогч талууд өөрсдийн ашиглаж буй Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд дурдсан хүчин төгөлдөр зорчих бичиг баримтдаа өөрчлөлт оруулах, эсхүл шинэчлэх тохиолдолд тухайн өөрчлөлт хүчин төгөлдөр болох өдрөөс доод тал нь гуч (30) хоногийн өмнө нөгөө талдаа мэдэгдэж, загварыг харилцан солилцоно.

10 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх, эсхүл тайлбарлахтай холбоотой үүссэн аливаа маргааныг зөвшилцөх, хэлэлцээ хийх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч талуудын харилцан тохиролцсоноор энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Ийнхүү оруулах нэмэлт, өөрчлөлт нь Хэлэлцээрийн 12 дугаар зүйлд дурдсан журмын дагуу хүчин төгөлдөр болно.

12 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухай мэдээллийг дипломат шугамаар харилцан солилцсоноос хойш 30 (гуч) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Энэхүү хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулах бөгөөд Хэлэлцэн тохиролцогч талууд хэлэлцээрийг дипломат шугамаар хүргүүлсэн мэдэгдлийн дагуу цуцална.

Энэ тохиолдолд цуцлах мэдэгдлийг нөгөө Тал хүлээн авсан өдрөөс хойш 90 (ер) хоногийн дараа энэхүү Хэлэлцээр хүчингүй болно.

Энэхүү хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 2013 оны 9 дүгээр сарын 4 - ны өдөр монгол, орос хэлээр тус бүх хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



**СОГЛАШЕНИЕ
МЕЖДУ ПРАВИТЕЛЬСТВОМ МОНГОЛИИ
И ПРАВИТЕЛЬСТВОМ РЕСПУБЛИКИ БЕЛАРУСЬ
ОБ ОТМЕНЕ ВИЗ**

Правительство Монголии и Правительство Республики Беларусь, в дальнейшем именуемые Сторонами,

руководствуясь желанием развивать дружественные отношения между двумя государствами,

желая упростить поездки граждан государств Сторон и отменить визовые требования для владельцев действительных проездных документов,

договорились о нижеследующем:

Статья 1

Граждане государств Сторон – владельцы действительных проездных документов, указанных в Статье 2 настоящего Соглашения, могут въезжать, выезжать, следовать транзитом и временно пребывать на территории государства другой Стороны без виз в течение периода, не превышающего 90 (девяносто) суток в календарном году со дня первого въезда.

Статья 2

Для целей настоящего Соглашения действительными проездными документами являются:

для граждан Республики Беларусь:

дипломатический паспорт гражданина Республики Беларусь;

служебный паспорт гражданина Республики Беларусь;

паспорт гражданина Республики Беларусь;

свидетельство на возвращение в Республику Беларусь (только для возвращения в Республику Беларусь);

для граждан Монголии:

дипломатический паспорт гражданина Монголии;

служебный паспорт гражданина Монголии;

национальный заграничный паспорт гражданина Монголии;

временный паспорт (проездной документ) Монголии.

Статья 3

Граждане государств Сторон – владельцы действительных проездных документов должны получить визу в соответствии с законодательством государства другой Стороны, если они намереваются находиться на территории этого государства в течение периода, превышающего 90 (девяносто) суток.

Статья 4

Граждане государства одной Стороны – владельцы дипломатических и служебных паспортов, выполняющие функции в дипломатических представительствах и консульских учреждениях, представительствах международных организаций, расположенных на территории государства другой Стороны, а также члены их семей могут въезжать, следовать транзитом, пребывать или выезжать с территории государства другой Стороны без виз в течение всего срока пребывания в должности.

Статья 5

Граждане государства одной Стороны – владельцы действительных проездных документов могут въезжать, выезжать и следовать транзитом через территорию государства другой Стороны через пункты пропуска на границе, открытые для международного сообщения, при условии соблюдения национального законодательства государства этой Стороны, применяемого к въезду, выезду и транзиту иностранных граждан.

Статья 6

Положения настоящего Соглашения не освобождают граждан государства одной Стороны от обязанности соблюдать законы и правила, действующие на территории государства другой Стороны, в течение периода их пребывания.

Статья 7

Настоящее Соглашение не затрагивает право компетентных органов государства каждой из Сторон отказать во въезде, сократить или ограничить срок пребывания на территории государства этой стороны в соответствии с национальным законодательством лицам, указанным в Статье 1 настоящего Соглашения.

Статья 8

Каждая из Сторон в целях обеспечения национальной безопасности, общественного порядка или здоровья граждан вправе полностью или частично приостановить действие настоящего Соглашения.

Сторона, принявшая такое решение, либо решение о возобновлении действия настоящего Соглашения, незамедлительно информирует об этом по дипломатическим каналам другую Сторону.

Статья 9

Стороны не позднее 30 (тридцати) дней с даты подписания настоящего Соглашения обменяются по дипломатическим каналам образцами действительных проездных документов, указанных в Статье 2 настоящего Соглашения.

Стороны будут информировать друг друга о любых изменениях в оформлении действительных проездных документов, указанных в Статье 2 настоящего Соглашения, не позднее чем за 30 (тридцать) дней до их вступления в силу и обмениваться образцами новых.

Статья 10

Споры, возникающие при толковании или применении настоящего Соглашения, разрешаются по дипломатическим каналам или путем проведения консультаций между Сторонами.

Статья 11

По взаимному письменному согласию Сторон в настоящее Соглашение могут быть внесены изменения и дополнения, которые вступают в силу в соответствии с положениями Статьи 12 настоящего Соглашения.

Статья 12


Настоящее Соглашение вступает в силу через 30 (тридцать) дней с даты получения по дипломатическим каналам последнего письменного уведомления о выполнении Сторонами внутригосударственных процедур, необходимых для его вступления в силу.

Настоящее Соглашение заключается на неопределенный срок и каждая из Сторон имеет право прекратить его действие, предварительно уведомив другую Сторону по дипломатическим каналам о таком намерении.

Настоящее Соглашение прекращает действие через 90 (девяноста) дней с даты получения другой Стороной указанного уведомления о прекращении действия.

Совершено в городе Улан-Баторе 4. сентября 2013 года в двух подлинных экземплярах, каждый на монгольском и русском языках, причем все тексты являются аутентичными.

ЗА ПРАВИТЕЛЬСТВО
МОНГОЛИИ



ЗА ПРАВИТЕЛЬСТВО
РЕСПУБЛИКИ БЕЛАРУСЬ

